



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/580

Зуунмод

Намрын ойжуулалт хүлээж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ногоон зурвас, Хавар, намрын улиралд орон нутаг, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр хийгдсэн ойжуулалтын ажлыг газар дээр нь шалгаж хүлээн авах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Хавар намрын ойжуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гурав дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх ажилд шаардагдах зардал 1,078,480 (нэг сая далан найман мянга дөрвөн зуун ная) төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4.Ойжуулалт хийсэн талбайн газрын солибоцолоор гаргаж, тухай бүр нь амьдралтын хувийг тооцож хүлээн авч, холбогдох тайланг гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Даш-Яйчил)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР